



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/189

Есөнбулаг

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд эрүүл ахуйн хяналт хийх, төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх үзлэг хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ч.Хандмаа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Э.Пүрэвжав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Ганчимэг	(Аймгийн Прокурорын хяналтын прокурор), (зөвшилцсөнөөр)
	Э.Одбаатар	(Аймгийн Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч)
	Т.Саранчимэг	(Аймгийн Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч)
	Г.Очирсүрэн	(Аймгийн Цагдаагийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч)
	Г.Төгсбилэг	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын албаны дарга, ургамал, хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
	Э.Танхилмаа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)
	Л.Сууд-Эрдэнэ	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын

		Хүнсний чанар, стандартын улсын хяналтын байцаагч
	Д.Должинпүрэв	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын улсын хяналтын байцаагч)
	О.Мөнхбаатар	(Эрүүл мэндийн газрын Хяналтын хэлтсийн дарга, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
	Г.Золзаяа	(Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)
	Б.Мөнхсайхан	(Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч)
	Х.Маралмаа	(Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)
	Б.Цэцгээ	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн)
	Б.Өрнөхбаяр	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн сорилтын нэгдсэн лабораторийн эрхлэгч)
	Ц.Долгормаа	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)
	Ч.Авирмэд	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
Нарийн бичиг:	Р.Цэнд-Аюуш	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Худалдаа, үйлчилгээний газруудад хийх хяналт, шалгалтыг чанартай зохион байгуулж, шалгалтын дүнг нэгтгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Ч.Хандмаа)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР